



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/145

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх сунгах тухай


Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Сайнцагаан сумын 7-р багт байрлах "Ирмүүн түшиг" ХХК-ны бөөний худалдаа, Айраг, Аравжих багт байрлах "Мандалговь -Хүнс", Боржигон багт байрлах "Жинд болор", Мандал багт байрлах "Дэгжин год", Сайхан-Овоо сумын "Ундррам-Онги" ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, Ээлт бор хайрхан ХХК-ны "Өргөө", Баянцахилдаг ХХК-ны "Нандин", Эрхэт ембүү ХХК-ны "Ембүү" зоогийн газрын архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаагаар сунгасугай.

Хоёр. Ирмүүн түшиг, Мандалговь -Хүнс ХХК-ны Айраг, Аравжих багт байрлах хүнсний дэлгүүр, Жинд болор, Дэгжин год ХХК-ны хүнсний дэлгүүр, Ээлт бор хайрхан, Баянцахилдаг, Эрхэт ембүү ХХК-ны зоогийн газрын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08⁰⁰ -24⁰⁰, Ундррам-Онги ХХК-ны хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09⁰⁰-21⁰⁰ цаг хүртэлх хугацаагаар тус тус баталсугай.

Гурав. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210406